



Хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот 17042 210136,
Хан-Уул дүүрэг Чингисийн өргөн чөлөө
НОМИН Юнайтед

Шуудангийн хайрцаг 2316
Утас: 7799 1000
Е-мэйл: unity@nomin.net
Вэб сайт: www.nominunity.mn

1 КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

2 ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС

3 КОМПАНИЙН БҮТЭЦ

4 САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЗӨВШӨӨРӨЛ

5 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

6 САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

7 НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

8 ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

9 R&D (СУДАЛГАА, ХӨГЖИЛ) ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

10 БИДНИЙГ СОНГОХ ШАЛТГААН

1 КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА


“Номин Юнити ББСБ ” ХХК нь 2002 оноос хойш санхүүгийн зах зээлд **23** жилийн турш тогтвортой үйл ажиллагаа явуулж **5** салбар, **30** гаруй ажилчидтайгаар Санхүүгийн зохицуулах хорооноос авсан зөвшөөрлийн дагуу санхүүгийн үйлчилгээгээ хүргэж байна.

Бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нь нийцэхүйц эрсдэлийн удирдлагын цогц шийдэл, санхүүгийн мэргэшсэн үйлчилгээг санал болгож, итгэлийг бүрэн хүлээж, санхүүгийн бүтээгдэхүүнээ тогтмол сайжруулан боловсруулж техник технологи үйл ажиллагааны шинэ шийдлийг үргэлж эрэлхийлэн ажилласаар ирлээ.

Бид үйл ажиллагааны чиглэлдээ Технологиор орон зай, цаг хугацаа-г хэмнэж, үйлчилгээгээр үйлдэл-г хялбаршуулан хүн бүрд зориулагдсан санхүүгийн мэргэжлийн үйлчилгээг хүргэхээр зорилго тавин ажиллаж байна.

“Номин Юнити ББСБ” ХХК нь харилцагчдын эрх ашгийг тэргүүн зэрэгт хүндэтгэн үзэж, санхүүгийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэн, эрх зүйн харилцааны хэм хэмжээг мөрдөн зүй бус хэлцэлд оролцохоос татгалзаж үйл ажиллагаандаа нээлттэй, шударга, ёс зүйг баримталж ажилладаг.

Монгол улсад хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, дотоод гадаадын бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд болон төрийн байгууллагуудтай урт хугацаанд хамтран харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ үргэлж биелүүлэн ажиллаж байна.



2

ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС

Бид 2002 онд байгуулагдсанаас хойш тасралтгүй 22 дахь жилдээ үйлчилгээ үзүүлж байна.



Эрхэм Зорилго

Технологиор орон зай, цаг хугацааг хэмнэж, үйлчилгээгээр үйлдлийг хялбаршуулах хүн бүрд зориулагдсан санхүүгийн мэргэжлийн үйлчилгээг бид хүргэнэ



Алсын Хараа

НОМИН ЮНИТИ ББСБ нь байгаль болон харилцагчид ээлтэй цаг хугацаа, үйлдэл, орон зай-г хэмнэх хүн бүрд зориулагдсан санхүүгийн үйлчилгээг бий болгоно




Үнэт зүйл

Мэргэжлийн хамт олон, технологид суурилсан, стандартыг хэрэгжүүлэгч, тогтвортой засаглал, төвлөрсөн санхүүгийн үйлчилгээ



3

КОМПАНИЙН БҮТЭЦ



4 САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЗӨВШӨӨРӨЛ



Номин Юнити ББСБ ХХК нь байгуулагдсан цагаас эхлэн Монгол улсад мөрдөгдөж буй хууль дүрэм журмыг мөрдөхийн зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагад бүрэн нийцүүлэн хамтран ажиллаж ирсэн бөгөөд 2024 онд үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай доорх зөвшөөрлийг аваад байна.



5 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЭРСДЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ

ТУЗ-ын дэргэдэх хороод (Компанид хяналт тогтооход оролцогч талуудад үүрэг хүлээнэ)

Хараат бус, ил тод байдал, манлайлал



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Байгууллагын зорилтыг биелүүлэх явц (Эрсдэлийн удирдлагыг агуулна)



ДОТООД АУДИТ

Хараат бус баталгаажуулалт



Нэгдүгээр шугам:

Үйл ажиллагаандаа байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хяналт тавих

Хоёрдугаар шугам:

Бодлого, чиглэлээр хангах, хяналт тавих, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Чиг үүргийн газрууд, Эрсдэлийн хороо, ЭУГ нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой тогтолцоо бодлого, аргачлалаар хангаж, дэмжлэг үзүүлнэ

Гуравдугаар шугам:

Зорилгыг биелүүлэхтэй холбоотой бүх асуудалд бие даасан, хараат бус баталгаажуулалт, зөвлөмжөөр хангах

Гадаад баталгаажуулах үйлчилгээ үзүүлэгч

Түлхүүр:

Хариуцлага, тайлагнал

Төлөөлөл, чиглүүлэлт нөөц, хяналт


Тохируулга, харилцааны зохицуулалт, хамтын ажиллагаа

5 ТУЗ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн нэр	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	Ажлын туршлага	ТУЗ гишүүнээр томилогдсон огноо, Ажилласан хугацаа	Хараат бус байдал	Хувьцаа эзэмшдэг эсэх, эзэмшдэг тохиолдолд хувь хэмжээ	Хуралдаанд оролцсон ирц
"НОМИН ЮНИТИ" ББСБ ХХК	ТУЗ-ийн дарга С.Хосбаяр	1. "НОМИН Холдинг" ХХК-ийн Санхүүгийн бизнес хариуцсан захирал 2024.10.14-одоог хүртэл 2. "НОМИН Холдинг" ХХК-ийн Санхүү удирдлагын газрын захирал 2021.01.11-2024.10.14 3. "НОМИН Холдинг" ХХК-ийн Борлуулалт үйлчилгээний салбарын захирал 2016.10.10-2021.01.11 4. "НОМИН Тав Трейд" ХХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал 2015.09.01-2016.10.10	2023.12.22 2 жил 2 сар	ТУЗ дарга	Хувьцаа эзэмшдэггүй	100%
	Хараат бус гишүүн Я.Нацагдорж	1. "НОМИН Юнити" ББСБ ХХК ТУЗ хараат бус гишүүн 2023.12.22- одоог хүртэл 2. "Бүрэнхайрхан сервис" ХХК- Гадаад худалдаа хариуцсан ажилтан- 2013.08.01-2023.12.21 3. Худалдаа хөгжлийн банк- Салбарын захирал- 2012.05.01-2013.07.01 4. Худалдаа хөгжлийн банк- Үүрэг гүйцэтгэгч 2011.12.01-2012.04.01	2023.12.22 2 жил 2 сар	Хараат бус гишүүн	Хувьцаа эзэмшдэггүй	100%
	ТУЗ-ийн гишүүн Б.Ариунжаргал	1. "НОМИН Холдинг" ХХК-ийн Санхүүгийн бизнес хариуцсан захирал 2022.06.08-2024.10.14 2. "Ариг банк" ХХК- Захирал- 2021.01.15-2022.06.27 3. "Улаанбаатар Импэкс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал- 2020.08.03-2021.01.04 4. "НОМИН Холдинг" ХХК-ийн Эрх зүйн газрын захирал 2019.08.03-2020.08.03	2023.12.22 1 жил 1 сар	Ердийн гишүүн	Хувьцаа эзэмшдэггүй	100%

6

Нийт хуралдсан тоо



ХУРАЛ

САЛБАР

Салбар нэгжийн тоог нэмэгдүүлэх шийдвэр



ГОЛЛОХ ШИЙДВЭР ТОГТООЛ

ХОРООД

Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Эрсдэлийн хороо, Актив, пассивын хороог тус тус байгуулсан



ГОЛЛОХ ШИЙДВЭР ТОГТООЛ

ИРЦ

100%

Хуралд оролцсон гишүүдийн ирц


ГОЛЛОХ ШИЙДВЭР ТОГТООЛ




ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчдад үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх шийдвэр


ЗЭЭЛИЙН БАГЦ */сая. төг/*




ХҮҮ ШИМТГЭЛИЙН ОРЛОГО */сая. төг/*




ХАРИЛЦАГЧИЙН ТОО




НИЙТ ХӨРӨНГӨ */сая. төг/*



ЦЭВЭР ЗЭЭЛ */сая. төг/*



ЦЭВЭР АШИГ */сая. төг/*





“Номин Юнити ББСБ” ХХК нь байгаль орчны нөхөн сэргээлт, орчны бохирдлыг бууруулах асуудлын хүрээнд дараах 2 журмыг дагаж мөрддөг. Үүнд:




Компанийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчинд сөргөөр нөлөөлж байгаа асуудлууд болон онцгой асуудлуудыг тодорхойлж, үнэлэлт өгөх үйл ажиллагааг зохицуулах “БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУДЫГ ТОДОРХОЙЛОН, ОНЦГОЙ АСУУДЛУУДЫГ ҮНЭЛЭХ ТУХАЙ ЖУРАМ”



Худалдаа үйлчилгээ, үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлыг анхан шатанд зүй зохистой ангилан ялгах, ангилсан хог хаягдлыг хадгалах, цуглуулах, эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлэх үйл ажиллагааг зохицуулах “ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАЖ ХАЯХ, ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ”

“Номин Юнити ББСБ” ХХК нь Тогтвортой хөгжлийн Зорилтууд болох Ээлтэй хот иргэдийн оролцоо, Хариуцлагатай хэрэглээг дэмжих, Хуурай газрын экосистемийг хамгаалах зорилтуудын хүрээнд байгальд ээлтэй олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, байгууллагуудтай хамтран ажилласаар ирсэн билээ.



2024 онд нийт **36,000** мод таригдах “ШАМБАЛА 2056” төсөлтэй хамтын ажиллагаа эхлүүлж цөлжилтийг сааруулах TECH LAND ART-д нэгдэж, нийт **100 сая** төгрөгийн үнийн дүнтэй **1.000 ш** модыг цөлд суулгаж, тарьж ургуулснаар агаарт **63.900 кг** нүүрс төрөгчийн давхар ислийг боловсруулж, **12.300 кг** хүчил төрөгчийг ялгаруулж, **20.200 кг** био масс бий болгож, **2 га** газарт цөлжилтийг сааруулж, ургамлан нөмрөг үүсгэжээ.



Энэхүү төслийн хүрээнд “Номин Юнити ББСБ” ХХК-ийн зүгээс

“ШАМБАЛА 2056” төсөлтэй хамтран “Номин Юнити” төгөл байгуулах ажил хийгдэж байгаа бөгөөд цаасны хог хаягдлыг багасгах ажлыг зохион байгуулан 15 сая гаруй цаасыг хэмнэх зорилго тавин хэрэгжүүлж байна.

7

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



"Номин Холдинг" ХХК 30 жилийн ойн ажлуудын хүрээнд "БЯЦХАН ЗҮРХЭНД ЖАРГАЛ ТҮГЭЭЕ" хандивын аяныг 2022 онд 30 жилийн ойгоороо Улаанбаатар хот болон орон нутгийн 60 гаруй салбар дэлгүүрээр дамжуулан нийт 208 сая төгрөгийн хандив цуглуулж, Монголын ирээдүй болсон 20 гаруй төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдийн хагалгааг амжилттай хийлгэн бяцхан зүрхнүүдийг аварч тэдний гэр бүлд аз жаргал ирээдүйг бэлэглэсэн билээ.

2024 онд "Номин Холдинг" ХХК болон "Зүрх мартаггүй" ТББ хамтран дахин төрөлхийн зүрхний гажигтай хүүхдүүдэд амьдрал бэлэглэхээр "БЯЦХАН ЗҮРХЭНД ЖАРГАЛ ТҮГЭЭЕ-2" хөтөлбөрт үйл ажиллагааг эхлүүлсэн. Уг төсөл нь 2024.04.12-с 2024.06.06-г дуустал Номингийн салбар дэлгүүрээр амжилттай явагдаж дууслаа.



8

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Нийт ажилтнуудын **80** гаруй хувь нь санхүү бизнесийн мэргэжилтэй ба энэ салбартаа бэлтгэгдсэн туршлагатай ажилтнууд байгаа нь компанийн хувьд мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр бүрэн хангагдсаныг илтгэн харуулж байгаа үзүүлэлт юм.

2024 онд хүний нөөцийн тогтвортой бодлого баримтлан ажиллаж, уг ажлын хүрээнд:



Шинэ ажилтныг удирдан чиглүүлэгч тэднийг компанийн соёлд суралцах тал дээр удирдан ажиллаж буй ажилчдад

НЭМЭЛТ УРАМШУУЛАЛТ олгох



Ажилчдынхаа сэтгэл ханамж, ажлын байрны орчин, тэдний нийгмийн амьдралд ээлтэй байх үүднээс ажилтан бүрд сар болгон цалингаас гадна хоол унааны мөнгө, улирлын бонус, мөнгөн хуримтлал болох "Ажилтан бүр саятан" санг олгож ажилчдынхаа үр бүтээмжтэй ажиллах орчныг бүрдүүлэн ажиллалаа. Мөн уян хатан цагийн системийг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

- Эрүүл мэнд болон эдийн засгийн хохирлоос хамгаалах зорилгоор бүх ажилчдадаа "Гэнэтийн Ослын Даатгал"-д хамруулсан.
- Мөн ажилтныхаа аюулгүй байдлыг ямагт нэгт тавьж "Эрсдэлийн Удирдлагын Газар"-аас жилд **2** удаа зохион байгуулдаг ХАБЭА сургалтад ажилчдадаа **100%** хамруулсан байна.
- Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Компанийн удирдлагын зүгээс ажилтнууддаа мэдлэг чадварыг сайжруулах тал дээр ихээхэн анхааран ажиллаж гадаад, дотоодын сургалт, семинарт хамруулан санхүүгийн салбарын мэргэшсэн боловсон хүчнийг бий болгох бодлого баримтлан ажилладаг юм.

Бүх ажилчдын эрх тэгш байдлыг тэргүүн зэрэгт хүндэтгэн үзэж цалинг

15% өсгөж



20+

Ажилчдадаа хөгжүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх, багийн ажиллагааг сайжруулах зорилготойгоор улирал бүр сургалт зохион байгуулсан



R&D (СУДАЛГАА, ХӨГЖИЛ) ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Бид үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн инновац, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэхийг зорьж:

1 Хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлчилгээг дараа төлөх нөхцөлөөр авах боломжийг хиймэл оюунд суурилан бий болгосон Omnipay аппликейшнийг хөгжүүлэн ажиллаж байна.



Цахим дэлгүүр

Хиймэл оюунд суурилсан, таны хүсэлд нийцсэн цахим дэлгүүрээс худалдан авалт хийх



Барааны зээл

Хүссэн бараа үйлчилгээг Хувааж төлөх болон Урт хугацаатай зээлээр авах боломж



Бэлэн мөнгө

Богино хугацаат хялбар шуурхай, бэлэн мөнгөний зээл авах боломжтой



Лоялти хөтөлбөр

Хамгийн өндөр хуримтлал бүхий лоялти хөтөлбөр, хуримтлалаа цуглуулаарай

2 Харилцагч байршил, цаг харгалзахгүй онлайнээр зээлийн бүтээгдэхүүний мэдээлэл болон зөвлөх үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.



Давуу талууд

Та өөрийн хүссэн зээлийн бүтээгдэхүүний мэдээллээ хэзээ ч, хаанаас ч хүссэн газраасаа **NominUnity chatbot** болон **www.nominunity.mn** вебсайт ашиглан авах боломжтой.



Хиймэл оюун (AI)



24/7 үйлчилгээ



Цаг хугацаа хэмнэх

Үйлчилгээний стандарт

Бид 2024 онд харилцагчдад үйлчилгээ үзүүлж буй ажилтан нэг бүрийн даган мөрдөх ёстой, хэвшүүлэх шаардлагатай ажил үүргүүдийг нэгтгэсэн, олон улсын стандартаар баталгаажсан, "Үйлчилгээний стандарт"-ыг шинээр нэвтрүүлэн Улаанбаатар хотын бүх салбар нэгжүүдийн үйлчилгээндээ мөрдөн ажиллаж байна.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТ НЭВТРҮҮЛЖ ЭХЭЛСЭН ТУХАЙ

Манай компани нь хэрэглэгчдэдээ мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан, тасалдалгүй, чанартай үйлчилгээг хүргэх зорилгоор **ISO27001:2022** Олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ жил магадлан аудитдаа амжилттай орж АНУ-ын IAS итгэмжлэлтэй Монсертф ТҮБ-ээс албан ёсоор гэрчилгээгээ гардан авлаа.

ISO 27001:2022 олон улсын стандартыг нэвтрүүлснээр харилцагч таны мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг өндөр түвшинд ханган ажиллах мөн нэгдсэн менежментээр удирдах боломжийг бүрдүүлж байна.

- ✓ Ижил төрлийн бусад стандартыг нэвтрүүлэх суурь
- ✓ Бизнесийн өрсөлдөөний давуу тал
- ✓ Үйл ажиллагааны тогтмол сайжруулалт
- ✓ Эрсдэлийн үр дүнтэй удирдлага
- ✓ Хэрэглэгчийн итгэл



ISO 27001:2022 Certified



Олон жилийн туршлагатай
мэргэшсэн боловсон
хүчинтэй



Зээлийн бүтээгдэхүүний
төрөлжилт сайн



Зээлийн хүүний
уян хатан нөхцөл



Төрөл бүрийн нэмэлт
үйлчилгээ, хөнгөлөлт
урамшуулал



Таны хэрэгцээ шаардлагад
тулгуурлан хамгийн
уян хатан нөхцөлүүд



Цахим зээлийн
үйлчилгээ



24 цагийн мэдээлэл
авах үйлчилгээ



Зээлийг богино
хугацаанд чирэгдэлгүй,
түргэн шуурхай олгодог



Эрсдэлийг бүрэн
даах чадвартай

ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

